



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/АЧ

Улаанбаатар хот

Пневмококкийн эсрэг вакцинаар  
дархлаажуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2; Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2; Дархлаажуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2; 11 дүгээр зүйлийн 11.2 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Пневмококкийн шалтгаант уушигны хатгалгаа өвчнөөс сэргийлэх пневмококкийн эсрэг 13 цэнт вакцинаар дархлаажуулах товыг нэгдүгээр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар, вакцины хэрэглэх зааврыг гуравдугаар, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийслэлийн Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн 2 сартайгаас 2 хүртлэх насны хүүхдийг товын дагуу дархлаажуулах арга хэмжээг 2016 оны бдугаар сарын 06-ны өдрөөс зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), Нийслэлийн эрүүл мэндийн газар (Ш.Энхбат), Сүхбаатар (Л.Баярхүү), Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв (Д.Сүнжидмаа)-ийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцинаар дархлаажуулсан тайлан, уг вакциныг үе шаттай нэвтрүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан 2017 оны хоёрдугаар улиралд багтаан Эрүүл мэнд, спортын яамны удирдлагын зөвлөлд танилцуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү)-д даалгасугай.

4. Хуваарилагдсан хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд бүртгэж, урсгал засвар, ашиглалтын байдалд хяналт тавьж ажиллахыг Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-г даалгасугай.


САЙД



С.ЛАМБАА

080760

Эрүүл мэнд, спортын сайдын  
2016 оны 06 сарын 28 өдрийн  
А/21 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт



НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ  
ПНЕВМОКОККИЙН ШАЛТГААНТ УУШИГНЫ ХАТГАЛГАА ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ  
ПНЕВМОКОККИЙНЭСРЭГ 13 ЦЭНТ ВАКЦИНААР ДАРХЛААЖУУЛАХ ТОВ

1. Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин(ПЭВ13)-ы гурван тунгаар дархлаажуулах тов

Дархлаажуулах нас	2016 оны 6 дугаар сар	2016 оны 8 дугаар сар	2017 оны 1 дүгээр сар
2 сар	ПЭВ13 вакцины 1 дэх тунг Тавт вакцины 1 дэх тунтай нэгэн зэрэг		
4 сар*		ПЭВ13 вакцины 2 дах тунг Тавт вакцины 3 дах тунтай нэгэн зэрэг	
9 сар**			ПЭВ13 вакцины 3 дах тунг улаанбурхангахай хавдарулаануудын эсрэг (УГУ) вакцины 1 дэх тунтай нэгэн зэрэг

Тайлбар: 2016 оны 06 дугаар сард 2 сартай хүүхдийг гурван тунгаар дархлаажуулна.

\*- ПЭВ13 вакцины 1 дүгээр тунд хамрагдсан хүүхэд

\*\* - ПЭВ13 вакцины 2 дугаар тунд хамрагдсан хүүхэд

2. Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин (ПЭВ13)-ы хоёр тунгаар дархлаажуулах тов

Дархлаажуулах нас	2016 оны 6 дугаар сар	2016 оны 8 дугаар сар
3 сар	ПЭВ13 вакцины 1 дэх тунг Тавт вакцины 2 дах тунтай нэгэн зэрэг	ПЭВ13 вакцины 2 дах тун
4 сар	ПЭВ13 вакцины 1 дэх тунг Тавт вакцины 3 дах тунтай нэгэн зэрэг	ПЭВ13 вакцины 2 дах тун
5 - 8 сар	ПЭВ13 вакцины 1 дэх тун	ПЭВ13 вакцины 2 дах тун

9 сар	ПЭВ13 вакцины 1 дэх тунг УГУ вакцины 1 дэх тунтай нэгэн зэрэг	ПЭВ13 вакцины 2 дах тун
10 сар - 1 нас 1 сар (13 сар)	ПЭВ13 вакцины 1 дэх тун	ПЭВ13 вакцины 2 дах тун
1 нас 2 сар (14 сар)	ПЭВ13 вакцины 1 дэх тунг А гепатитын эсрэг вакцины 1 дэх тунтай нэгэн зэрэг	ПЭВ13 вакцины 2 дах тун
1 нас 3 сар (15 сар) - 1 нас 11 сар (23 сар)	ПЭВ13 вакцины 1 дэх тун	ПЭВ13 вакцины 2 дах тун

Тайлбар:2016 оны 06 дугаар сард 3 сартайгаас 23 сартай байх хүүхдийг хоёр тунгаар дархлаажуулна. Нэг ба хоёрдугаар тунгийн тун хоорондын завсар 2 сар байна.

Эрүүл мэнд, спортын сайдын  
 2016 оны 06 сарын 05 өдрийн  
 А/Ч/0 дугаар тушаалын 2 дугаар  
 хавсралт



НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ  
 ПНЕВМОКОККИЙН ШАЛТГААНТ УУШИГНЫ ХАТГАЛГАА ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ  
 ПНЕВМОКОККИЙН ЭСРЭГ 13 ЦЭНТ ВАКЦИНААР ДАРХЛААЖУУЛАХ  
 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ


№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтрах байгууллага
Нэг. Зохион байгуулалт				
1.1	Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн 2 сартайгаас 2 хүртлэх настай (23 сар) хүүхдийн нарийвчилсан судалгаа гаргах	2016 оны 5 дугаар сар	Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн ЭМТ, ӨЭМТөв	НЭМГ, ХӨСҮТ
1.2	Пневмококкийн эсрэг 13 цэнт вакциныг дагалдах хэрэгслэлийн хамт түгээх	2016 оны 5 дугаар сар	ХӨСҮТ	Дүүргийн ЭМТ, ӨЭМТөв
1.3	Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн ӨЭМТ-ийн дархлаажуулалтын нэгжийг хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжөөр хангах	2016 оны 5 дугаар сар	ХӨСҮТ	Дүүргийн ЭМТ, ӨЭМТөв
1.4	Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн 2 сартайгаас 2 нас хүртлэх хүүхдийг пневмококкийн эсрэг 13 цэнт вакцинаар товын дагуу дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулах	2016 оны 6, 8 дугаар сар, 2017 оны 1 дүгээр сар	Дүүргийн ЭМТ, ӨЭМТөв	НЭМГ, ХӨСҮТ
1.5	ПЭВ13 вакцины хамралтын цахим бүртгэлийн санг байгуулах	2016 оны 6 дугаар сар	ХӨСҮТ	Судалгааны баг

1.6	ПЭВ13 вакцинаар товын дагуу дархлаажуулсан хамралтын болон ДДУХ-ын мэдээг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх	2016 оны 6, 8 дугаар сар, 2017 оны 1 дүгээр сар	Дүүргийн ЭМТ, ӨЭМТөв	ХӨСҮТ
1.7	ПЭВ13 вакцинаар дархлаажуулсан үйл ажиллагааны явцын тайлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Дархлаажуулалтын зөвлөх хороо(ДЗХ)-нд танилцуулах	2017 оны 3 сар	ХӨСҮТ	НЭМГ Судалгааны баг
1.8	ПЭВ13 вакцинаар дархлаажуулсан үйл ажиллагааны явцын тайланг вакциныг үе шаттай нэвтрүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг ЭМСЯ-ны Удирдлагын зөвлөлд танилцуулах	2017 оны 6 сар	ХӨСҮТ	НЭМГ Судалгааны баг
Хоёр. Тандалт, хяналт үнэлэгээ				
2.1	Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэгт уушигны хатгалгаа оноштой хэвтэн эмчлүүлж байгаа болон тэдэнтэй хамт амьдардаг 5 хүртэлх насны хүүхдийн дунд идэвхтэй тандалт хийх	2016 оны 6 дугаар сараас	ХӨСҮТ	Судалгааны баг
2.2	Дархлаажуулалтын нэгжийн үйл ажиллагаа, дархлаажуулалтын явцад дэмжлэгт хяналт хийх, ажлын байранд сургалт зохион байгуулах	2016 оны 6, 8 дугаар сар, 2017 оны 1 дүгээр сар	ХӨСҮТ	НЭМГ, Судалгааны баг
2.3	ПЭВ13 вакцины дархлаажуулал-тын дараах урвал хүндрэлийг тандан судлах	2016 оны 6 дугаар сараас	ХӨСҮТ	Судалгааны баг
2.4	“Пневмококкийн вакцины үр дүнгийн үнэлгээ судалгаа”-ны үр дүнг ЭМСЯ, ДЗХ-нд танилцуулах	2018 оны 9 дүгээр сар	Судалгааны баг	ХӨСҮТ

Гурав. Сургалт сурталчилгаа

3.1	Эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зориулсан Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааны гарын авлага боловсруулах, хэвлүүлэх, түгээх	2016 оны 6 дугаар сар	ХӨСҮТ	Дүүргийн ЭМТ, ӨЭМТөв
3.2	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “ПЭВ13 вакцинаар дархаажуулах” давтан сургалтыг зохион байгуулах	2016 оны 11 дүгээр сар	ХӨСҮТ	НЭМГ, Судалгааны баг
3.3	Вакцинатор “Нөөц сувилагч” бэлтгэх сургалт зохион байгуулах	2016 оны 10 дугаар сар	ХӨСҮТ	ЭМХТ, Судалгааны баг
3.4	Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцинаар дархлаажуулах талаар телевиз, радио, гар утас, төвийн сонин хэвлэл зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах	2016 оны 6, 8 дугаар сар, 2017 оны 1 дүгээр сар	ХӨСҮТ	НЭМГ, Дүүргийн ЭМТ, ӨЭМТөв
3.5	Эцэг, эхчүүд, иргэдэд зориулсан сурталчилгааны материалыг түгээх, сурталчилах	2016 оны 6, 8 дугаар сар, 2017 оны 1 дүгээр сар	ХӨСҮТ	НЭМГ, Дүүргийн ЭМТ, ӨЭМТөв

Эрүүл мэнд, спортын сайдын  
2016 оны 06 сарын 03 өдрийн  
А/210... дугаар тушаалын 3 дугаар  
хавсралт



## ПНЕВМОКОККИЙН ЭСРЭГ 13 ЦЭНТ ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

### Найрлага

Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин нь Streptococcus pneumoniae нянгийн 13 дэд хэвшинжийн (1, 3, 4, 5, 6A, 6B, 7F, 9V, 14, 18C, 19A, 19F, 23F) гадаргуугийн эсрэгтөрөгчийн сахарид, сахуугийн CRM<sub>197</sub> уураг, сахуугийн хоргүйсүүр, хөнгөнцагааны фосфат агуулсан.

### Хэрэглэх заалт

Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцины найрлагад орсон 1, 3, 4, 5, 6A, 6B, 7F, 9V, 14, 18C, 19A, 19F, 23F дэд хэвшинжээр үүсгэгддэг пневмококкийн халдвараас сэргийлэх зорилгоор 2 сартайгаас 17 насны хүмүүст хэрэглэнэ.

### Савлалт

Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин нь шингэн хэлбэртэй цагаан өнгийн цийдмэг. Нэг флаконд 0.5 мл – 1 хүн тунгаар савлагдсан.

### Тарих тун хэмжээ, тов, бусад вакцинтай харилцан үйлчлэл

Пневмококкийн эсрэг 13 цэнт вакциныг 3 тун хийлгэх шаардлагатай. Эхний тунг 2 сартай, хоёр дахь тунг 4 сартай, гурав дахь тунг 9 сартайд нь тус тус хийнэ.

Булчинд тарьж хэрэглэнэ. Нярай хүүхдэд гуяны гадна дунд хэсэгт, 9-с дээш сартай хүүхдэд бугалганы делтойд булчинд тарина. Тарихаасаа өмнө вакциныг зөөлөн сэгсэрч, нэгэн жигд суспенз болгосны дараа хэрэглэнэ. Нэг удаагийн ариун зүү тариур хэрэглэн 0.5 мл тунгаар булчинд тарих ба цусны судас, мэдрэлийн судалтай ойр тарихаас болгоомжилно. Вакциныг өгзөгний булчинд тарихгүй.

Пневмококкийн эсрэг 13 цэнт вакциныг сахуу, хөхүүл ханиад, татран, В хэвшинжийн хемофилюс инфлюэнза (Хиб), гепатит В, улаанбурхан, улаанууд, гахай хавдар, салхинцэцэг, С хүрээний менингококкт халдвараас сэргийлэх болон халдварт саагийн эсрэг идэвхигүйжүүлсэн вакцинтай нэг өдөр хэрэглэж болно. Хүний дархлал хомсдолын вирусын халдвартай хүнд хийж болно.

**Пневмококкийн эсрэг 13 цэнтвакцин хийлгэсэн хүүхдэд:**

Энэхүү пневмококкийн эсрэг 13 цэнт вакцин нь(пневмококкийнэсрэг 7 цэнт)вакцинд агуулагддаг 7 хэв шинжийг агуулсан ба адилхан CRM<sub>197</sub>уургийг ашиглан коньюгат (нийлмэл)технологиор үйлдвэрлэгдсэн.

Өмнө нь пневмококкийн эсрэг 7 цэнтвакцинаар дархлаажуулсан хүүхдийг вакцины товллын аль ч үед пневмококкийн эсрэг 13цэнт вакцинаар солин дархлаажуулж болно.

**Гаж нөлөө:**

6 долоо хоногоос 5 хүртэлх настай хүүхдэд: Хэсэг газрын урвал болон халуурах, цочромхой болох, нойрмоглох, тайван бус болох, хоолонд дургүй болох, бөөлжих, суулгах, тууралт гарах зэрэг шинжүүд гарч болно.

**Эсрэг заалт:**

Вакцины найрлагад орсон бодист, тухайлбал сахуугийн хоргүйсүүрт хэт мэдрэг хүнд эсрэг заалттай.

**Хадгалах, тээвэрлэх:**

Вакциныг +2<sup>o</sup>C+8<sup>o</sup>C-д тээвэрлэж, хадгална. Хөлдөөж болохгүй, хэрэв хөлдсөн бол хэрэглэж болохгүй.

Үйлдвэрлэсэн: Пизер лимитед сэндвич, Их Британи улс

Эрүүл мэнд, спортын сайдын  
 2016 оны 06 сарын 22 өдрийн  
 А/Д/10 дугаар тушаалын 4 дүгээр  
 хавсралт



ХҮЙТЭН ХЭЛХЭЭНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХУВААРЬ

Байгууллага	Мөсөн ханатай хөргөгч /МКФ074/			Тог тогтворжуулагч			Вакцин зөөврийн сав		
	Тоо	Нэгж үнэ /төг/	Нийт үнэ /төг/	Тоо	Нэгж үнэ /төг/	Нийт үнэ /төг/	Тоо	Нэгж үнэ /төг/	Нийт үнэ /төг/
Сонгинохайрхан дүүргийн 2, 4, 25, 30, 31-р хорооны ӨЭМТ	5	1,787,589	8,937,947	5	119,590	597,950	10	68,660	686,595
Сүхбаатар дүүргийн 10, 14, 16-р хорооны ӨЭМТ	3	1,787,589	5,362,768	3	119,590	358,770	6	68,660	411,957
Нийт	8	3,575,179	14,300,715	8	239,180	956,720	16	137,319	1,098,552
<b>НИЙТ ДҮН</b>	<b>16,355,987 төгрөг</b>								